



СУМЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Хүн амын тоо, яс үндэс уламжлал, ёс заншлын онцлог

Ахай бэйсийн хошуу нь анхлан ХҮIII зууны үед буй болсон юм. Тус хошууны нутаг нь Хэвт ёсны тэргүүн /1908/ оны байдлаар хойгуураа Баян-Эрхтий, Хэрлэнгийн тохой, зүүгээрээ Баянбулаг, Язаар Эрэгнэг, өмнүүрээ, Холбоо хонгор, Бор-Өндөр, Яргайт, Бумба-Ус зэрэг газраар хиллэхийн дээр нутгийнхаа дөрвөн талд Баян-Эрхтий, Баянбулаг, Баян Ноён, Баян Хараат хэмээх “Баян” гэсэн нэр бүхий уул устай хойш урагшаа зууван “Хонины өвчүү” хэлбэрийн газартай байжээ. Сэцэн хан аймгийн Ахай бэйсийн хошууныхны дээр үед Хардал бэйсийн хошууныхан хожим нь Боржигон Сэцэн вангийн хошууны харъяат болоод сүүлд биеэ даасан хошуу болоход Боржигон Сэцэн вангийн хошууных болон өөр нутгаас шилжин ирсэн хүмүүсээр бүрдэл болжээ. Энэ байдал нь тус хошууны отог, овгийн бүтцээс харагдана. Ахай бэйсийн хошууны харъяат ардын нэг хэсэг нь Халхын Түшээт Хан аймгийн Дайчин бэйсийн хошуунаас /одоогийн Дундговь аймгийн Адаацаг сумаас/ ХҮIII зууны сүүлчээр нүүдэллэн ирж суурьшсан байна. Тэгээд ч тэдний удмынхныг “Цоохорынхон” гэдэг байжээ. 1690-ээд оны сүүлчээр Манжаас Халх, Өөлдийг дайчлах үед Галдан Бошигт Хан Дархан уулын газар байрлаж ахуйд Түшээт Хан аймгийн говийн хошуунаас дайчлагдсан цэргийн ардын үлдэл нь сайхь Цоохорынхон болно. Ахай бэйсийн хошууны уугуул иргэд нь Боржигон, Халх, Баягуд зэрэг овгийн хүмүүс болохоор байна.

Манжийн ноёрхлын үеэс нэрлэж ирсэн Халхын дөрвөн аймгийн нэрийг өөрчлөхөд мөнөөхөн Сэцэн Хан аймгийн Ахай бэйсийн хошууг газрын нэрээр Хан Хэнтий уулын аймгийн Дархан уулын хошуу хэмээх болжээ. Тус хошуу нь 1923 оны 6-р сард 4 сум, 12 баг, 58 арван болж, 579 өрх 2571 хүн амтайгаар байгуулагдсан байна. Үүний дараа тус улсын хүн ам цөөтэй зарим хошуудыг татан буулгаж өөр хошуудтай цомхтгоход Дархан уулын хошуу нь 1928 онд Дашбалбар уулын хошуунд нэгтгэгдсэн байна. Хуучин үеэс эхлэн удаан хугацаагаар уламжлан ирсэн аймаг, хошуу, сумын нутаг дэвсгэрийн хуваарийг бүрмөсөн өөрчилж, эдийн засгийн талаар тус орны нутаг дэвсгэрийг нь ангилан хувааж, хүн амын байршил, ард олны аж байдалд зохицуулан шинээр 13 аймаг байгуулсан 1931 оны үед Хан Хэнтий уулын аймгийн зохион байгуулалтанд өөрчлөлт орж, тус аймаг, Хэнтий, Дорнод гэсэн хоёр аймаг болоход Хэнтий аймгийн 28 сумын бүрэлдэхүүнд Дархан уулын хошуу нь Дархан, Мандал гэсэн хоёр сум болсон байна. 1930 онд хуралдсан тус аймгийн хошуудын төлөөлөгчдийн анхдугаар хурлын тогтоолын дагуу 1931 оны 4-р сарын 29-нд Бор хужир гэдэг газарт Дархан сумыг эмхлэн байгуулах шийдвэр гарчээ. Чингээд 1932 оны үед Дархан суманд Оцолсансар уулын хошууны 200 өрх ирж Буйлан гэдэг газар нийлснээр Дархан сум 13 багтай болсон бөгөөд сумын төв нь

нүүдэллэсээр 1937 онд Эрэгнэгт, 1938 онд Шавартайд, 1939 онд Дархан уулын зүүн өмнө биед Мэргэн хошууны баруун сугад одоогийн энэ газарт төвлөрчээ. Дархан сум нь 1956 оны 08 дугаар сарын 01-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Баянмөнх сумтай нийлж, 1957 оны 08 дугаар сарын 01-нд дахин бие даасан сум болон байгуулагджээ.

Одоогийн Дархан сум Сум нь засаг захиргааны хувьд 4 багт хуваагддаг. Үүнд: Дотуур булаг /1-р баг/, Хараат /2-р баг/, Шажин /3-р баг/, Мэргэн хошуу баг /4-р баг/. 2016 оны жилийн эцсийн байдлаар 1903 орчим хүн амтай, 225743 толгой малтай байна.

Хүн ам зүйн бүрэлдэхүүн болон хүн амын тоо

№	Нас, насны бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	бүгд
	Хүн амын тоо	991	912	1903
1	0-4 нас	114	115	229
2	5-9 нас	99	75	174
3	10-14 нас	53	72	125
4	15-18 нас	79	63	142
5	19-24 нас	123	103	226
6	24-29 нас	126	83	178
7	30-34 нас	73	72	145
8	35-39 нас	77	47	124
9	40-44 нас	54	65	119
10	45-49 нас	61	67	128
11	50-54 нас	62	57	119
12	55-59 нас	38	37	75
13	60-65 нас	19	31	50
14	65-аас дээш нас	31	38	69

№	Сумын төвд	Хөдөөд	Нийт
Өрхийн тоо	145	513	658
Суурин хүн ам			1903


Сумын онцлогын талаар

Дархан сум нь Хэнтий аймгийн баруун урд захын цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг учир бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх боломжтой. Ялангуяа бог мал. Монгол улсад хамгийн анх нэгдлийн малыг малчдад түрээслүүлэн, мал хувьчлалыг эхлүүлсэн анхдагчууд. Одоо 185,0 мянган толгой малтай. Сүүлийн 4 жил тэмээгээрээ аймагтаа тэргүүлж байгаа. Дархан ууланд Аргал, буга зэрэг ховор ан амьтантай. Ангийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой. Бор-Өндөр сум, Говь-Сүмбэр аймагт хүн ам олноор суурьшиж уул уурхай хөгжиж байгаа учир мах, сүү, сүүн бүтээгдхүүн хүнсний ногоо, оёдлын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мөн зэргэлдээх сумдын ноос, ноолуур угаах, утас ээрэх зэрэг бага оврын үйлдвэрүүд хөгжих боломжтой. Ашигт малтмалын арвин их нөөцтэй. /хайлуур жонш, төмрийн хүдэр, полиметалл г.м/ Монгол Улсын хайлуур жоншны баяжмалын 80 гаруй хувийг тус сумын нутгаас олборлож экспортоор гаргадаг. Газрын гүний усны маш их нөөцтэй. Бор-Өндөр сум, Дорноговь аймгийн Иххэт сумын ундны болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг 1987 оноос хойш хангаж ирсэн.

/Жилд 1,3 сая шоо метр/ Байгалийн энэ их нөөцөөс орж буй татвар хураамжийн тодорхой хэсэг нь орон нутгийн хөгжилд зориулагдахгүй аймаг, улсын төсөвт орж байгаад нутгийн иргэд таагүй ханддаг.

Хилийн зурлага, хиллэдэг аймаг, сум

Хойд талаараа Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумтай 23 км, зүүнээрээ мөн аймгийн Баянмөнх сум, урдуураа Бор-Өндөр сумтай, зүүн өмнөд талаараа Дорноговь аймгийн Иххэт сумтэй 66 км, баруун өмнөд талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан сумтай 74 км, баруун талаараа Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумтай 72 км газраар тус тус хиллэдэг. Нийт хилийн шугамын урт нь 314км байна



2.Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, онцлог

2.1.Газар зүйн байршил

Дархан сум далайн түвшнээс дээш 1200-1750 м өргөгдсөн. Цөлөрхөг хээрийн бүсэд хамаарагддаг. Хойд талаараа Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумтай 23 км, зүүнээрээ мөн аймгийн Баянмөнх сум, урдуураа Бор-Өндөр сумтай, зүүн өмнөдөөрөө Дорноговь аймгийн Иххэт сумтэй 66 км, баруун өмнөдөөрөө Дорноговь аймгийн Даланжаргалан сумтай 74 км, баруун талаараа Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сумтай 72 км газраар тус тус хиллэдэг. Нийт хилийн шугамын урт нь 314 км байна

2.2 Газар нутгийн хэмжээ

Нийт газар нутгийн хэмжээ **445482га.**


Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	4060834	90,9
Ойн сан бүхий газар	0	0

Усан сан бүхий газар	462	0,10
Тусгай хэрэгцээний газар	33025	7,41
Тосгон, суурингийн газар	3560,6	1,03
Дэд бүтцийн газар	2351,0	0,52


2.3 Газарзүйн онцлог.

Тус сумын газрын гадарга нь далайн төвшинөөс дээш 1148,1-1715 метрт өргөгдсөн. Газрын гадаргын хувьд намхан ухаа, гүвээтэй тал нутаг зонхилох ба нийт нутгийн гадаргын байдлаар нь: Уулархаг гадарга, Нам уулсуудын хоорондох тэгш тал, Хөндийн тэгш гадаргууд гэж ангилна. Уулын гадаргууд 1100 м-ээс дээш өргөгдсөн нам толгод, уулархаг газрууд орно. Харин уул хоорондын өргөн хөндий тэгш талууд нийт талбайн 50 гаруй хувийг эзэлдэг. Хамгийн өндөр цэг нь Дархан уул, далайн төвшингөөс дээш 1715 м, хамгийн нам цэг нь Хэрлэн голын сав газар далайн төвшингөөс 1148,1 м болно.

Сумын газрын зураг



4. Малын тоо, ангилал, сүүлийн 5 жилээр график



5. Амьтан, ургамлын аймаг, төрөл зүйл, ангилал


Дархан сум нь амьтны аймгийн төрлөөр баян нутаг билээ. Ховор ан амьтан: Дархан ууланд 1980-аад оны эхээр буга согоо, аргаль угалз нутагшиж ирсэн ба ховор ан амьтны төрөлд орох гозоорой зурам нь мөн ууланд элбэг тааралдана. Аргаль угалз нь сүүлийн арваад жилд Дархан уулаас Эрэгнэг уул, Ноён Баян уул, Адагийн уулнуудад тархан нутагшиж тоо толгой нь өсөж байна. Одоогийн байдлаар буга 30 гаруй болж, аргаль хонины тоо толгой 280 орчимд хүрчээ. Жигүүртэн шувуу: Махчин шувууд: Энэ төрлийн шувуудаас Дархан сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн бүргэд, шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, тас, элээ, шар шувуу зэрэг шувуудаас гадна ховор шувуу болох ёл нь Дархан ууланд үзэгдэх болсон байна. Усны шувууд: Тал хөндийгөөр Монгол Улсын улаан номонд орсон нэн ховор Гангар хун, Хар тогоруу, Цэн тогоруу болон овогт тогоруунууд тааралдах ба Хэрлэн гол, нуур тойрмын хөвөө орчимд галуу, нугас, ангир, хун овогт тогоруу зэрэг усны шувууд элбэг байна. Бусад элбэг шувууд: Хөхвөр тагтаа, соотон гуйвалга, хотны бүгээхэй, хэрээ, бөвөөлжин өвөөлж, болжморууд, монгол божрог, улаавар бужмар, ногтруу, тольт дунхай зэрэг шувуудаас гадна агнуурын шувуудаас дагуурын ятуу, цагаан ятуу, тоодог шувууд тааралдана.

5.2 Ургамлын төрөл зүйлийн байдал

Сумын ургамлан нөмрөгийн үндсэн төрхийг тал хээрийн ургамалжилт бүрдүүлэх ба ангилан үзэхэд 11 анги, 18 бүлэг төрөл, 61 төрлийн бэлчээр байна. Уулын хээр хазаарт, үетэн-алаг өвст, алаг өвст-үетэн, хялгана хазаар, өвс-хиагт бэлчээр голлон тархах баэнд хазаар өвс, шивээт хялгана, хиаг, дааган сүүл, ленийн ботууль, морин царгас, гол гэсэр, гичгэнэ зэрэг ургамал голлон тархдаг.

Уулс болон дов толгодын хоорондох өргөн хөндийн шавранцар хөрстэй газруудаар хялгана-агь-үетэнт, хазаар өвс-хиагт, хазаар өвс-агьт, хазаар өвс-үетэнт-алаг өвс, харгана-үетэнт хээрийн бэлчээр зонхилж байхад элсэнцэр хөрстэй газраар хялганат ба хялгана-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, даагансүүлт, хазаар өвст болон харганат эвшлүүд голлоно. Том жижиг голуудын хөндий, нууруудын хотсоор улалж, үетэн, алаг өвс зонхилохоос гадна Хэрлэн голын хөндийгөөр бургас ургана. Голын хөндийн дийлэнх хэсэг нь ихээхэн хуурайшиж хээржсэн бөгөөд энд өвслөг ургамлаас хиаг, хазаар өвс, саман ерхөг, адамсын агь, улалж, дэрс, лууль, хэрс зэрэг ургамал голлоно. Нуурын захын мараалаг, хжуирлаг нам хотсуудаар дэрс болон галофит ургамлууд ургана.

5.3. зураг Амьтан , ургамлын төрөл зүйлийн байдал ЗУРАГ



6. Түүхийн дурсгалт газрууд

Дархан сумын нутаг нь эртнээс түүхт газар билээ. Тэдгээрээс заримыг нь дурьдвал тус сумын зүүн урд байдаг Чандмань элснээс задын чулуу, хүрэл зэвсгийн үеийн сум, эдлэл олддогийн дээр сумын баруун урдуурх говирхог газраар цахиур зэв, чулуун зэвсгийн үлдэцүүд элбэг тааралддаг хийгээд Хэрээгийн ногоон толгой дахь хадны зураг сэлт нь чулуу, төмөрлөг зэвсгийн үеэс энэ газар хүн оршин сууж байсныг гэрчилнэ. Түүнчлэн Ходой хэмээх газар хүн бүхий чулуун хөрөг, Талын Хөшөөт гэдэг газар байгаа

хөшөө чулуу нь YI-X зууны үед Монгол оронд оршиж байсан Түрэг угсаатны түүхийн дурсгал болно. Энэчлэн Ходой гэдэг газарт хүн чулуу байгаа нь эртний Түрэг угсаатны шүтдэг “Худай” тэнгэрийн нэртэй ч холбоотой байж магадгүй гэж түүхчид үздэг байна. Түүнчлэн тахилгатай их, бага уул овоо 20 орчим байгаа нь эртний Монголчуудын уул усаа шүтдэг байсан заншлын үлдэгдэл юм. Мөн Дархан, Эрэгнэгийн уулнаа Монголын эрт хожуу үеийн гэгдэх булш, бичигт хад чулуу тааралддаг.

Хожуу үеийн түүхийн дурсгал болох шарын шашны сүм хийдийн туурь, байшин барилгын үлдэгдэл, их замын мөр мэт нь нилээд байхын гадна бичиг түүх болон хүн амаар уламжлагдан ирсэн орон нутгийн мэдээ захиа, үлгэр домог, шүлэг зохиол бий. а. Хүн чулуу: Тус сумын 1-р багийн нутаг Ходой гэдэг газар шаргал боржин чулуугаар хүний бүтэн биеийг дүрсэлсэн хүн чулуу бий. Хүн чулууны толгой хагарч алга болсон ба Монгол нутагт тааралддаг Түрэгийн үеийн хүн чулууны хийц загвартай, цаг үе, учир холбогдол нь өнөө хэр тодорхой бус түүхийн дурсгал юм. Мөн 2-р багийн нутаг Талын Хөшөөтийн Түрэгийн үеийн чулуун хөшөө, 3-р багийн нутаг Ногоон уулын /толгой/ Хүннүгийн үеийн сүг зураг бүхий бичигт хад зэрэг өнөө хэр судлагдаагүй түүхийн дурсгал олон байна. б. Сүм, орон хийд: Ахай бэйсийн хошуу хийд болон Гачидын дацан, Зүүн зангийн жас, Хараатын сүм зэрэг багаахан хийд дацан олон байжээ. Гол хошуу хийд нь Дархан уулын зүүн дор Цээлийн дэнж хэмээх /1787/ газар байсан Ахай бэйсийн хошуу тамга оршдог хийд болно. Тус хийдийн нэр нь “Ганданшадублин” гэгдэж Цогчин, Чойр, Мамба, Ламрин зэрэг 4 том дацан бүхий 700-гаад лам хувраг шавилан суудаг хошууны гол хийд болж 1938 он хүртэл үйл ажиллагаагаа явуулж байв. Хийдийн модон дуганы үлдэгдэл одоо хэр сумын төв дээр байсаар байна. Тус сумын нутаг дэвсгэрт ХVIII-XIX зууны үеийн сум хийдүүдийн туурь үлдэгдэл олон байдаг. Үүнд: Гачидын дацан, Шар нуурын дуган, Мандалын сүм, Дэрсэнэ усын зүүн зангийн жас, Зараагийн сүм, Дээд Хавцалын дуган, Доод Хавцалын дуган, Хараатын сүм, Хүйхийн сүм зэрэг 16 орчим сүм дуган, дацангийн туурь үлдэгдэл байна. в. Булш хиргисүүр Сумын нутаг дэвсгэрт судлагдаагүй булш хиргисүүр олон тааралдана. Үүнээс: Дархан уулыг тойроод болон дотор бэл хөвөөгөөр 60 орчим Хүннүгийн үеийн гэгдэх булш хиргисүүр байдаг. Мөн Эрэгнэг уул, Буйлан уул, түүний ойр орчим, Ходой зэрэг бусад газруудад булш олон байна. г. Төмөр дөш: Дархан ууланд байдаг төмөр дөш нь Чингис хаан болон хойшхи үе, түүний өрлөг баатруудтай холбоотой түүхийн домог бүхий дурсгал гэгддэг. Тус ууланд байсан төмрийн дарханы газарт дайчин баатруудын дайн тулаанд хэрэглэх зэвсгийг уг төмөр дөшөөр хийдэг байжээ. Түүхийн дурсгалт тус төмөр дөшийг Ардын хувьсгалын эхэн үед Улсын Түүхийн Музейн сан хөмрөгт аваачсан гэгддэг ба түүнийг орлуулсан жижиг төмөр дөш өнөөг хүртэл уулнаа Дотуурын булагийн эхийн баруун дээд болд чулуун тавцан дээр байрлаастай байдаг. Тус төмөр дөшийг нутгийн иргэд тахин шүтсээр ирсэн байна. д. “Ягаан” хэмээх Шагдарын агуй: Дархан нутгийн ард түмэн газар шороо, эрх чөлөөнийхөө төлөө хэзээнээс нааш тэмцсээр иржээ. Нутгаас тодорсон сайн эрс гадаадын шунахай худалдаачин, эзэрхэг түрэмгийлэгч нартай эрэлхэгээр тэмцэж ирсэн байна. Хүрээнээс Жанчхүү ордог гүнж зам Дархан уулын өврөөр, Буйлангийн араар замнан тус хошууны дундуур өнгөрөн гардаг байв. Иймээс хуучны сайн эрс Дархан

ууланд бүгж тэдэнтэй тэмцдэг байсан ба тэдний нэг Дархан уулын энгэрээс гүнж замыг тосон хятад наймаачдыг айлгаж явсан “Ягаан” хэмээх Шагдар гэдэг сайн эрийн орогнож байсан агуй Дархан уулнаа бий. Энэ нь Дархан уулын гол Тахилгат шовх өндөрийн урдах өндөр хаданд таван метр урт, нэг хагас метр өргөн, хүн босоогоор явах өндөр, дотроо ямар нэгэн эд зүйлс тавьж байсан гэхээр хоёр чулуун тавцантай, урдуураа чулуун хэрэмтэй, хойшоо харсан хавцал-орц байдаг. е. Гэрэлт хөшөө: Дархан сумаас төрж гарсан билгүүн их яруу найрагч Төрийн соёрхолт Ринчины Чойномын цээж хөрөг бүхий гэрэлт хөшөөг 1991 онд сумын төвд босгон уран бүтээлийн гэр музейг байгуулсан байна. Мөн нэрт яруу найрагчийн төрсөн Бор Ухаа гэдэг газар түүний төрсөн бууцан дээр болон найрагчийн сурч байсан сургуулийн үүдэнд 2006 онд босгосон чулуун боржин самбар бүхий гэрэлт хөшөөнүүд бий. Нэгдлийн олон тооны мал сүргийг цасан шуурганаас хамгаалж яваад амь эрсэдсэн малчин Д.Лхамсүрэнгийн гэгээн дурсгалд зориулж гэрэлт хөшөөг 1979 онд сумын төвд босгосон байна.

1. Эргэнэг уулын дурсгал



1. Ногоон уулын дурсгал



2. Хойд зараагийн энгэрийн дурсгал



Тахилын онгон: Зараа уулын урд бэлд уртрагийн дагуу байрлалтай 4 ширхэг тахилын онгон нэг дор бүлэглэн оршино. Тахилын онгонуудыг хавтгай нимгэн чулуудыг хайрцаглан хана босгож чулуугаар дарсан байна. Уулын урд орших тоногдсон хиргисүүрээс баруун зүгт 500 метрт оршино.



1. Босгоны хурлын туурь



1. Хар өндөр орчмын дурсгал



1. Зараа булангийн баруун үзүүрийн булш



1. Талын хөшөө чулуу



1. Ноён уулын дурсгалууд



7.Байгалийн баялаг , ашигт малтмалын орд газар

Дархан сум нь ашигт малтмалын төрлөөр арвин, нөөц ихтэй нутаг юм. Үүнд: Бор-Өндөрийн УБҮ, түүний үйлдвэр уурхайн эдэлбэр газар, үүнээс томоохон бүлэг ордод Адаг, Бор Хужир, Дэвтээр, Цагаан-Өндөр, Шивээн Цагаан-Өндөр, Хажуу-Улааны хайлуур жоншны орд газрууд, Баргилт, Хөх Овоот, Хөх Өндөрийн бүлэг төмрийн хүдрийн орд газрууд, Зүүн, баруун, Дунд Мандал зэрэг нүүрсний орд газрууд тус тус орно. Мөн эдгээр орд газруудаас судалгааны явцад зэс, мөнгө, хар тугалга, цайрын эрдэсжсэн зэрэг өнгөт металлын цэгүүд тогтоогдсон байна. Дээрхи ашигт малтмалыг түшиглэн Бор-Өндөрийн УБҮ ажиллаж байна. Одоогийн байдлаар сумын хэмжээнд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах 4 аж ахуйн нэгжийн 19 тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй газрын нийт хэмжээ нь 1972.44га байгаа нь сумын нутаг дэвсгэрийн 14,5%-ийг эзэлж байна.

8.Жижиг дунд үйлдвэрлэл

Одоогоор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч байхгүй болно.

9. СУМЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

Тус сум нь **“Хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч сум”** болох зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцлийг бүрдүүлэх
- Ажлын байрыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- Нийгмийн дэд бүтэц, Орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх